



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН НЭР: ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ҮАГ-НАГ-/2018/01-НА

ШИЛЭН ДАНС

ТӨСВИЙН ЕРӨНӨЙЛӨН ЗАХИРАГЧ | ЯАМ | АГЕНТЛАГ | ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙ НЭГЖ | ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР | АЖ АХУЙ НЭГЖ, ТӨРИЙН БҮС БАЙГУУЛЛАГА, ИРГЭН

Дэлгэрэнгүй хайлт | Татан буугдсан байгууллагууд

Эхлэл | Орон нутаг | Мэдээ мэдээлэл | Холбоо барих | Нэвтрэх

БАЯНХОНГОР

Улаанбаатар	Баян-өлгий	Баянхонгор	Булган	Говь-алтай	Архангай
Говьсүмбэр	Дархан-уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Хэнтий
Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Хөвсгөл
Сэлэнгэ	Төв	Увс	Ховд		

Баянхонгор аймаг-Сум

- Баянхонгор сум
- Баянцагаан сум
- Баянбулаг сум
- Баянговь сум
- Баянлиг сум
- Баян-Овоо сум
- Баян-Өндөр сум
- Баянцагаан сум

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, мэдээллийг 87,8 хувьтай байршуулжээ.

Баянхонгор хот

2018.10.31

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:
Баянхонгор аймаг дахь
Төрийн Аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор
Б.Мөнхбат
Аудитын менежер
Д.Цэцэгмаа
Ахлах аудитор
Б.Должмаа
Аудитор
П.Мөнх-Эрдэнэ
Б.Нарангэрэл

2018 оны 10 дүгээр сарын 31
Тайланг Баянхонгор аймаг
дахь Төрийн аудитын газрын
Цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.bayankhongor.mn
Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70442584, 70442424
дугаарын утсаар харилцана
уу.
ХАЯГ: Баянхонгор аймаг
дахь Төрийн аудитын газар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН	4
НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН	7
1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, мэдээллийг хугацаанд нь 87,8 хувьтай байршуулжээ.....	7
Шилэн дансны тухай хуулийн 6.1-д заасан мэдээллийг хугацаанд нь 84,5 хувь, 6.4-д заасан мэдээллийг 91,0 хувьтай байршуулжээ.....	7
.....	7
Шилэн дансны мэдээллээ зарим байгууллага мэдээллийн самбараар хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлээгүй байна.....	13
2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгж байгууллагууд цахим хуудаст хамрагдаагүй, мэдээлэл байршуулах үүргээ хэрэгжүүлээгүй байна.	14
Хуулийн 3.1.3-т хамрагдах байгууллагууд хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй байна.	14
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 3.1.4-т заасан аж ахуйн нэгжүүд мэдээллийг байршуулаагүй байна.	14
Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.	15
3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дах хэсэгт заасан байгууллага, албан тушаалтнууд холбогдох хяналтыг тухай бүр хэрэгжүүлж ажиллаагүйгээс алдаа зөрчил гарсаар байна.	16
Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг бүх шатны ИТХ бүрэн хэрэгжүүлээгүй байна.....	16
Хуулийн 3.1.4-д хамаарах байгууллагуудын шилэн дансанд мэдээлэх үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагч хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	17
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн ч тодорхой үр дүн гараагүй, зөрчил дутагдал давтагдан гарсаар байна.....	18
Холбогдох байгууллагын санал.....	19
Саналд өгөх тайлбар:.....	19
ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	21
Тайлан баталгаажуулсан тушаал.....	23
Хавсралт судалгаа.....	24-45

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	- ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НАГ	- НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР
НА	- НИЙЦЛИЙН АУДИТ
УИХ	- УЛСЫН ИХ ХУРАЛ
ИТХ	- ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ЗДТГ	- ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
СТСХ	- САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС
СХАА	- САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА
ОНХС	- ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН
ХАА	- ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
ТЕЗ	- ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ТШЗ	- ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
ИНХ	- ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төсвийн байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/06 тоот тушаалаар батлагдсан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, аудитын дүнг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹, 3.1.2²-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3³, 3.1.4⁴, 3.1.5⁵-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх;
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5-д заасан хуулийн этгээд, төрийн байгууллага, албан тушаалтныг бүрэн хамруулан 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгав.

¹ “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”

² “төрийн өмчит үйлдвэрийн газар”

³ “хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани”

⁴ “улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага”

⁵ “төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч”

Үндсэн мэдээлэл

Баянхонгор аймгийн хэмжээнд Шилэн дансны цахим хуудаст нийт **236** байгууллага бүртгэлтэй бөгөөд хуулийн 3.1.1-3.1.3-д хамаарах **218** байгууллага, 3.1.4-3.1.5-д хамаарах **16** байгууллага байгаа ба татан буугдсан Заг сумын эмийн эргэлтийн сан, Орог нуур-Түйн голын сав газрын захиргаа гэсэн **2** байгууллага бүртгэлээс хасаагүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байгууллагын цэс үүсгэх, бүртгэлийг шинэчлэх, тэдгээрт хяналт тавихтай холбоотой харилцааг журамлаагүйгээс мөн зарим байгууллагын өмчийн хэлбэрийг буруу бүртгэсэн байгууллагын нэр өөрөөр бичигдэх зэрэг зөрчилтэй байна. Тухайлбал:

- *“Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба” төсвийн байгууллагыг ОНӨААТҮГ-аар;*
- *Баянхонгор аймгийн Ахмадын хороог ТӨААН-ээр;*
- *“Баянхонгор аймгийн ахмад настны асрамжийн үйлчилгээний төв” төсвийн байгууллагыг ТББ-аар;*
- *Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрыг Баянхонгор сумын харьяанд байршуулсан;*

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн асуудлын шинжилгээнээс 1 дүгээр зорилтын 3 дахь асуудал, 3 дугаар зорилтын 3 дахь асуудал орон нутгийн түвшинд хамааралгүй гэсэн чиглэлийг цахим хурлаар өгсөн тул энэ чиглэлийг баримталж ажиллалаа.

Аудитад 2018 оны 3-р улирлын байдлаар 234 байгууллага хамрагдлаа. Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагч нарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2017 оны 4-р улирлын байдлаар үнэлэхэд Баянхонгор аймаг нь мэдээллийг 96.3%-тай мэдээлж, тайланг 77.7%-тай илгээж, хэрэгжилт дунджаар 87%-тай үнэлэгдсэн байна. Мөн аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчит 199 байгууллагыг хамруулан 2017 оны 4-р улирал, 2018 оны 1-р улирлын байдлаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтан, аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хорооны хуралд танилцуулан ажиллажээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хууль хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст

байршуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгаж, дүн шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулан аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль
- ✓ Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн аудитын тухай хууль
- ✓ Шилэн дансны тухай хууль
- ✓ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- ✓ Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль
- ✓ Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Засгийн газрын 2016 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- ✓ Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Хүндрэл бэрхшээл

Шилэн дансны мэдээллийг хянах эрхээр орж нэгтгэлийг авч үзэхэд “Хавсралт дээр тохиргоо хийгдээгүй байна. Нэгдсэн админд хандаж тохиргоо хийлгэнэ үү” гэж системээс мессеж өгч алдаа гарч байсан ба аудитын хавсралт судалгааны маягтыг бөглөхөд заавал тухайн байгууллага руу энгийн хандалтаар хандаж нарийвчлан үзэх шаардлага үүсч байгаа нь цаг хугацаа ихээхэн шаардагдсан болно. Мөн Шилэн дансны цахим хуудсанд тавьсан мэдээллийг үзэхэд төвөгтэй, хэвлэж авах боломжгүй, тухайн цэсэнд хэдэн хүн нэвтэрч мэдээлэл үзсэнийг харах боломжгүй байгааг цаашид анхаарч, системд шинэчлэлт хийж хөгжүүлэх шаардлагатай байна.


НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

Бүлэг 1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, мэдээллийг хугацаанд нь 87,8 хувьтай байршуулжээ.

Шилэн дансны тухай хуулийн 6.1-д заасан мэдээллийг хугацаанд нь 84,5 хувь, 6.4-д заасан мэдээллийг 91,0 хувьтай байршуулжээ.

Баянхонгор аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 - 3.1.2 дахь заалтад хамаарах төрийн болон орон нутгийн өмчит 209 байгууллага, орон нутгийн өмчит 6, Төрийн өмчит үйлдвэрийн газар 2, нийт 217 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагджээ.



Тус аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцэст хуулийн 3.1.1, 3.1.2-д хамрагдах 209 байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансанд мэдээллээ байршуулж байсан бол 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 217 болж нэг байгууллага буюу “Баянхонгор-Эрчим хүч” ОНӨЦТХХК-ны хуулийн үйлчлэлд хамаарах ангилал өөрчлөгдөж, 7 байгууллага шинээр нэмэгдсэн байна. Үүнд:

1. Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба
2. Баянхонгор сумын 14 дүгээр Цэцэрлэг
3. Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэг
4. “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ
5. “Баянхонгор хайрхан фарм” ОНӨААТҮГ
6. “Баянхонгор Нью майнинг” ХХК

7. Авто тээврийн төв

"ТОГТСОН ХУГАЦАА"-нд цахим хуудас, мэдээллийн самбараар тайлагнах мэдээллийн төрөл тус бүрээр нь авч үзвэл:

Шилэн дансны тухай хуулийн заалт	Байгууллагын тоо	Тухайн мэдээлэл хамааралгүй	Мэдээлбэл зохих	Үүнээс			
				Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Мэдээлээгүй	
6.1.1	Тухайн жилийн төсөв	217	9	208	170	27	11
	ОНХС-ийн төлөвлөгөө	217	196	21	19	2	-
	ХАА-ны төлөвлөгөө	217	30	187	162	18	7
6.1.3	Дараа жилийн төсвийн төсөл	217	6	211	149	1	61
6.1.4	Санхүүгийн тайлан /хагас жил/	217	5	212	180	6	26
	Санхүүгийн тайлан /Жилийн эцсийн /	217	7	210	195	1	14
6.1.5	ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	217	8	209	188	1	20
	Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	217	60	157	99	15	43
6.1.6	Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	217	13	204	182	4	18
НИЙТ ДҮН			325	1620	1343	75	202

Аудитаар ТЕЗ-ийн дүнгээр хуулийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д хамаарах мэдээлбэл зохих нийт 3976 мэдээллээс 84,5%-ийг буюу 3362 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 361 мэдээллийг хугацаа хоцроож, 253 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

-6.1.1-д заасан тухайн жилийн төсөв, ОНХС-ийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 18 байгууллага буюу 4,3 хувь нь мэдээлээгүй;

-6.1.2-т заасан төсвийн гүйцэтгэлийг мэдээлбэл зохих 2983 мэдээллээс хугацаанд нь 2644, хугацаа хоцроож 286 мэдээллийг мэдээлсэн ба нийт 98,2 хувьтай байршуулсан байгаа нь өмнөх оны аудитын дүнгээс 0.9 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

-6.1.3-т заасан дараа жилийн төсвийн төслийг 61 байгууллага буюу 29 хувь нь мэдээлээгүй;

-6.1.4-т заасан хагас жилийн санхүүгийн тайланг 26 байгууллага буюу 12,2 хувь, бүтэн жилийн санхүүгийн тайланг 14 байгууллага буюу 6,7 хувь нь мэдээлээгүй;

-6.1.5-т заасан ТЕЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 20 байгууллага буюу 9,5 хувь, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 43 байгууллага буюу 27,3 хувь нь мэдээлээгүй;

-6.1.6-т заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарыг 18 байгууллага буюу 8,8 хувь нь тус тус мэдээлээгүй байна.

Тухайн мэдээлэл гарснаас хойш “ДОЛОО ХОНОГ”-ийн дотор мэдээллийг байршуулсан эсэхийг шалгахад дараах байдалтай байна.

Шилэн дансны тухай хуулийн заалт	Хамааралгүй	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Мэдээлээгүй
6.4.1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	46	171	171	0
6.4.2. Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	152	65	65	0
6.4.3 Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	65	152	152	0
6.4.6. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	216	1	1	0
6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	217	0	0	0
Нийт дүн	696	389	389	0

Аудитад хамрагдсан 217 байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 6.4⁶ дэх заалтад хамаарах мэдээлбэл зохих 6183 мэдээллээс 91,0 хувь буюу 5629 мэдээллийг цахим хуудсанд байршуулжээ.

Хуулийн 6.4.1⁷, 6.4.2⁸, 6.4.3⁹ дахь заалтын дагуу холбогдох байгууллагууд мэдээллийг бүрэн байршуулсан байна.

⁶ “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”

⁷ “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”

⁸ “тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт”


⁹ “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”

Шилэн дансны тухай хуулийн 6.4.4¹⁰, 6.4.5¹¹ дахь заалттай холбоотой 88161,0 сая төгрөгийн 3390 гүйлгээнээс 7103,7 сая төгрөгийн 371 гүйлгээг давхардсан тоогоор нийт 110 байгууллага мэдээлээгүй, мөн хуулийн 6.4.8¹²-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 1731,2 сая төгрөгийн 2404 шийдвэрээс 259,6 сая төгрөгийн 183 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Иймд төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагуудаар шилэн дансанд мэдээллийг нөхөн байршуулж, хэрэгжилтийг тооцож ирүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд шилэн дансанд байршуулах нийт 265 мэдээллээс 175 мэдээлэл байршуулж, 90 мэдээлэл буюу 39,8 хувийг мэдээлээгүй зөрчил илэрсэн тул нөхөн мэдээлэх албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэхээр шийдвэрлэв. Тухайлбал:

- Хот тохижилт ОНӨТҮГ хуулийн 6.4.5, 6.4.8-д хамаарах 111,1 сая төгрөгийн 11 гүйлгээг мэдээлээгүй;
- Хог тээвэр ОНӨААН хуулийн 6.4.5 хамаарах 59,1 сая төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй;
- Хонгор шинэ агро ОНӨААТҮГ хуулийн 6.4.5, 6.4.8-д хамаарах 120,1 сая төгрөгийн 11 гүйлгээг мэдээлээгүй;
- Баянхонгор хайрхан фарм ОНӨААТҮГ хуулийн 6.4.4, 6.4.5, 6.4.8-д хамаарах 651,3 сая төгрөгийн 48 гүйлгээ, 11 шийдвэрийг мэдээлээгүй;



¹⁰ “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”

¹¹ “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”


¹² “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”

Хуульд заасны дагуу 7 хоногт мэдээлэх мэдээллийг харуулбал:

/Сая төгрөгөөр/

Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх мэдээлэл	Нийт		Үүнээс: мэдээлээгүй	
	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	762	6352	62	158
6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	879	14829	132	1707.6
6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	1749	66980,3	177	5238.1
6.4.8 Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл	2404	1731,2	183	259,6
Нийт	5794	89892.5	554	7363.3

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагуудын мэдээлэл байршуулсан байдлыг өмнөх онуудын аудитын дүнтэй харьцуулбал:



Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны мэдээллийг байршуулах төлөвлөгөөг аймгийн СТСХ-ийн дарга 2017 оны 09 дүгээр сард шилэн дансны үндсэн 3-н цэсийг ажил үүргийн хуваарьтай нь уялдуулж төлөвлөгөө гаргажээ.

Хуваарийн дагуу мэдээлэл байршуулсан байдлыг шалгахад мэдээлэх үүрэг хүлээсэн албан тушаалтнууд Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт цэсний нийт мэдээллийн 32,5 хувийг, төсөв, гүйцэтгэл цэсний 40,6 хувийг, бусад цэсний 33,3 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудаст мэдээлэх албан тушаалтнаар нь харуулбал:

Д/д	Хариуцсан албан тушаалтны нэр	Мэдээлвэл зохих	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцроож мэдээлсэн	Мэдээлээгүй	Хугацаа хоцроосон, мэдээлээгүй зөрчлийн эзлэх хувь
1	О.Эрдэнэ-Оюун	27	8	19	0	70%
2	Ц.Дагвадорж	15	10	5	0	33%
3	В.Содномдаржаа	16	8	8	0	50%
4	Б.Жамьяндорж	17	14	3	0	18%
5	Г.Должинсүрэн	6	5	1	0	17%
6	Р.Янжмаа	24	24	0	0	
7	Ц.Цэвээнсүрэн	134	83	31	20	38%
	Нийт дүн	239	152	67	20	38%

Дээрх албан тушаалтнууд шилэн дансны мэдээлэл оруулахдаа хуулийн 4.1¹³-д заасан зарчмыг баримтлаагүй байна. Тухайлбал:

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7¹⁴-дах хэсэгт заасны дагуу аймгийн ОНХС-аас бусад улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг мэдээлээгүй орхигдуулсан байна;
- Мөн тус цэсэнд зөвхөн концессоор хэрэгжиж байгаа арга хэмжээг мэдээлж, мэдээлэхдээ тухайн арга хэмжээний нэрээ мэдээлээгүй, КО 1 төсөл, КО 2 төсөл гэх мэтээр бичсэн нь иргэдэд ойлгомжгүй, мэдээлэл авах боломжийг олгоогүй байна;
- ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг мэдээлэхдээ төсөвт өртөг, тухайн жилийн төсөв, гэрээний дүн зэргийг орхигдуулсан;
- Төсвийн хэтрэлт, хэмнэлт, түүний шалтгаан тайлбарыг мэдээлээгүй;
- Аудитын дүгнэлтийг байршуулахдаа толгойг нь буруу харуулж хавсаргасан;
- Аудитын тайланг оруулаагүй;
- Төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах шийдвэрүүдийг тухай бүр бүрэн мэдээлээгүй;

Иймд цаашид шилэн дансанд байршуулахдаа мэдээллийг сайтар хянаж, хуулийн хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

¹³ “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”

¹⁴ “хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр”

Шилэн дансны мэдээллээ зарим байгууллага мэдээллийн самбараар хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заажээ.

Аудитаар түүврийн аргыг ашиглан Баянхонгор сумын 24 байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийг шалгахад зарим байгууллага олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг бүрдүүлээгүй, байршуулсан мэдээлэл нь ач холбогдлоо алдсан, тогтоосон хугацаанд нь шуурхай, иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1¹⁵-дэх заалтыг зөрчиж байна. Тухайлбал:

- *Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь мэдээллийг баталгаажуулаагүй, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг самбараар огт мэдээлээгүй;*
- *4 дүгээр Цэцэрлэг нь хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийг самбарт байршуулаагүй;*
- *Аймгийн Нийтийн номын сан нь 2018 оны 06 сараас хойш төсвийн гүйцэтгэлийг мэдээлээгүй;*
- *Аймгийн Прокурорын газар нь шилэн дансны мэдээллээ самбараар мэдээлээгүй цахим дэлгэцээр мэдээлж байгаа нь иргэд, олон нийтийн мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангаагүй;*
- *Онцгой байдлын газар, Эрдэнэмандал ахлах сургууль, хүүхдийн Тэмүжин театр зэрэг байгууллагууд нь албан өрөөндөө самбараа байршуулж мэдээлсэн;*

Эндээс үзэхэд иргэд, олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжгүй бөгөөд шилэн дансны тухай хуулийн 4.1-д заасан мэдээллийн ойлгомжтой, ач холбогдолтой байх зарчмыг алдагдаж байна. Иймд цаашид Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг мөрдүүлж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

¹⁵ “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”

Бүлэг 2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх

2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгж байгууллагууд цахим хуудаст хамрагдаагүй, мэдээлэл байршуулах үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Хуулийн 3.1.3-т хамрагдах байгууллагууд хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т хамаарах “Чандмань-Баянхонгор” ХК 2018 оны эхний 9 сарын байдлаар хуулийн 6.8.2¹⁶-т заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, төсөл, арга хэмжээнд тендер зарлаагүй, зарим төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйтэй холбоотой тендерийн ерөнхий мэдээлэл хамааралгүй гэж мэдээлжээ.

Дээрх аж ахуйн нэгжийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6.8.1¹⁷-д заасан бусад ажил гүйлгээ гараагүй тул байршуулах мэдээлэл байхгүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 3.1.4-т заасан аж ахуйн нэгжүүд мэдээллийг байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4¹⁸ -т хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.9¹⁹ дэх заалтад заасны дагуу гэрээний үндсэн дээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээг “Шанхай Констракшн групп” ХХК-аас бусад аж ахуйн нэгжүүд цахим хуудсанд цэс үүсгэж, мэдээллийг байршуулаагүй байгаа нь нэг удаа тендерт шалгарч ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгж шилэн дансны цахим хуудсанд цэс үүсгэж

¹⁶ “худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”

¹⁷ “тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр”

¹⁸ “3.1. Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:...3.1.4. улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;”

¹⁹ “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.”

дараа нь мэдээлэл байршуулах шаардлага гарахгүйгээс системд ашиглагдахгүй цэстүүд байрших нь хуулийн холбогдох заалт хэрэгжих боломжгүйг харуулж байна.

Иймээс цаашид хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгжүүдийн шилэн дансанд байршуулах мэдээллийг энэхүү заалтын хэрэгжилтийг хангах үүднээс аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд батлагдсан маягаар улирал бүр нэгтгэж, бүрэн мэдээлж байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэст хүргүүлэв.

Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5²⁰-т заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд аймгийн ТЕЗ-ийн цахим хуудсанд аймгийн СТСХ-ээр дамжуулан мэдээллийг байршуулж байсан бөгөөд 2018 оны 02 дугаар сараас эхлэн байгууллагын нэрээр цахим хуудсанд цэс нээж, Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор баталсан журмын 19 дүгээр хавсралтын дагуу улирал тутам мэдээллийг оруулж байгаа хэдий ч дараах зөрчилтэй байна. Үүнд:

- *Хэрэгжилтийн явц /өссөн хувиар/ болон тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд гаргасан зардал /өссөн хувиар/ гэсэн талбарыг бүх аж ахуйн нэгжүүд бөглөөгүй орхигдуулсан, буруу мэдээлсэн.*
- *Нийтийн Тээврийн үйлчилгээ эрхэлдэг “Төгстөгөлдөр үйлс” ХХК аймгийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй, 2018 оны 03 дугаар улирлын санхүүжилтийг мэдээлээгүй.*
- *Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ эрхэлдэг “Сод баян элбэг”, “Тэмүүлэл” цэцэрлэгүүд 2018 оны 03 дугаар улирлын санхүүжилтийг мэдээлээгүй.*
- *Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ эрхэлдэг “Ханбаянхонгор” ХХК 2018 оны 03 дугаар улирлын мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрч аудитын явцад зөрчлийг арилгуулав.*
- *Оточномгон өрхийн эмнэлэг аймгийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй зөрчил илэрлээ.*

Иймд ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээнд гүйцэтгэгчийн шилэн дансанд мэдээлэх үүрэг, хариуцлагын талаар тусгах, хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан болон хүлээлгэх хариуцлагыг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-д тодорхой тусгах шаардлагатай байна.

²⁰ " төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч."

Бүлэг 3. Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дах хэсэгт заасан байгууллага, албан тушаалтнууд холбогдох хяналтыг тухай бүр хэрэгжүүлж ажиллаагүйгээс алдаа зөрчил гарсаар байна.

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг бүх шатны ИТХ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1²¹-т заасны дагуу бүх шатны ИТХ, ИНХ нь хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд аймгийн ИТХ-ын 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 16/491 тоот албан бичгээр ирүүлсэн тайлангаас үзэхэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн дунд сургалт явуулж, хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тогтоол гаргаж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан гэх боловч алдаа зөрчил бүрэн арилахгүй байна.

Баянхонгор сумын 3, 7 дугаар багийн ИНХ-ын дарга нартай ярилцлага хийхэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ойлголтгүй, хийж хэрэгжүүлсэн ажил байхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2²²-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь 2017 оны 4-р улирал болон 2018 оны 1-р улирлын байдлаар хуулийн 3 дугаар зүйлийн 3.1²³-д заасан төрийн болон орон нутгийн өмчит 199 байгууллагыг хяналт шалгалтад хамруулжээ. Тус хяналт шалгалтаар байгууллагууд нь мэдээллийг хугацаанд нь оруулсан ч дутуу хоосон хадгалдаг, аливаа шийдвэрийн хавсралт файлыг оруулдаггүй, улирлын тайланг илгээсэн ч шилэн дансны мэдээллийг нэр төдий оруулдаг зэрэг зөрчлүүд илэрсэн ба хяналт шалгалтын хугацаанд зөрчлийг арилгуулж, шалгалтын дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороонд танилцуулж, гарсан шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллажээ.

²¹ " Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ."

²² " Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ."

²³ " Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгөө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна."

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан журмын 8.1²⁴-д заасны дагуу ТЕЗ-ийн харьяаны байгууллагууд тайлангаа улирал бүр ирүүлдэг эсэх талаар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргаас тодруулахад хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд улирлын тайлангаа ирүүлдэггүй бөгөөд үүнтэй холбоотой зөвлөмжийг 2017 оны эцэст хүргүүлсэн гэсэн тайлбарыг өгсөн.

Аудитаар Санхүүгийн хяналт аудитын алба нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.2²⁵-т заасны дагуу ТЕЗ-ийн 2018 оны 2 улирлын шилэн дансны тайланд хяналт шалгалт хийж холбогдох байгууллагад хүргүүлээгүй зөрчил илэрсэнд хууль, журмын дагуу тайланг хянаж, нэгтгэж, холбогдох газарт хүргүүлж ажиллах, мөн ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудын улирлын тайланг хугацаанд нь бүрэн ирүүлэх талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Хуулийн 3.1.4-д хамаарах байгууллагуудын шилэн дансанд мэдээлэх үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагч хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2²⁶-т заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь 3.1.3²⁷, 3.1.5²⁸ дахь хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын шилэн дансны мэдээлэлд тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч 3.1.4²⁹-д хамаарах байгууллагуудын мэдээлэлд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын явцад 2018 оны 3 дугаар улирлын тайлан илгээсэн байдлыг 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөр шилэн дансны хяналтын эрхээр хандаж шалгахад “тогтсон хугацаанд” илгээх тайланг 13, “тухай бүр” мэдээлэх тайланг 8, нийт 21 байгууллага хуулийн хугацаанд тайлангаа илгээгээгүй байна.

²⁴ " Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр ТЕЗ-ийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана."

²⁵ "Дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ.."

²⁶ " Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ."

²⁷ " хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани."

²⁸ " төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.."

²⁹ " улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага.."

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн ч тодорхой үр дүн гараагүй, зөрчил дутагдал давтагдан гарсаар байна.

2017 оны 3-р улиралд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нэгдсэн удирдамжаар хийсэн аудитаар аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга болон СТСХ, Санхүүгийн хяналт аудитын албанд нийт 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлжээ.

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжилт
Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаярт		
1	Шилэн дансны тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг аймгийн ИТХ-ын ажлын албаны нэг ажилтны, сумдын ИТХ-ын нарийн бичгийн даргын ажлын байрны тодорхойлолтод нэмж оруулах, энэ чиглэлээр хийсэн ажлынх нь тайланг улирал тутам авч байх, дээрх албан тушаалтнуудын ажлыг нь дүгнэхдээ “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьсан байдал”-ыг харгалзах.	2018 оны 06 дугаар сарын 05 ны өдрийн 1а/289 тоот албан бичгээр Шилэн дансны тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны Санхүү, төсөв хариуцсан ажилтан болон сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга нарын ажлын байрны тодорхойлолтод дээрх чиг үүргийг тусгахаар зөвлөмж хүргүүлжээ. Мөн хариуцлагагүй ажилласан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны Санхүү төсөв хариуцсан ажилтанд сануулах арга хэмжээ авч ажиллажээ.
Аймгийн Засаг дарга Г.Батжаргалд		
2	Харьяа байгууллагуудын дарга нарт Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг баримтлан мэдээллийг бүрэн байршуулж, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын төсвийн захирагч, санхүүгийн ажилтнуудыг арга зүйгээр хангаж ажиллах	2018 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 5/766 тоот албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу 5 өрхийн эмнэлэг, 7 хувийн цэцэрлэг, тусгай шилжүүлгийн байгууллагуудын нягтлан бодогчид, сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын төсөв захирагч, дарга, захирал, Нягтлан бодогчдод сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллажээ.
Санхүүгийн хяналт, аудитын албанд		
3	Төсвийн байгууллагуудын дарга нарт Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.2 дахь заалтыг баримтлан мэдээллийн үнэн зөв байдал, хугацаанд хяналт тавьж, холбогдох ажилтнуудыг арга зүйгээр хангаж зөвлөгөө өгч ажиллах.	2017 оны 12дугаар сарын 15-ны өдрийн 151 тоот албан бичгээр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт хийсэн тухай тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлжээ.

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д аймгийн Төрийн аудитын газраас 2017 оны 3-р улирлын байдлаар хийсэн нийцлийн аудитаар 27 байгууллагад санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр байршуулах, аудитын дүгнэлт, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг байршуулахтай холбоотой

нийт 706,1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж зөрчлийг бүрэн барагдуулсан байна.

Аудитаар нийт 7363,3 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 941,6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 6421.7 сая төгрөгийн зөрчилд хууль, тогтоомжийг мөрдөж, зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Холбогдох байгууллагын санал


**БАЯНХОНГОР АЙМГИЙН
 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
 АЛБА**
 64101 Номгон, Баянхонгор сум


2018.10.31 № 190
 танай 2018.10.30-ны № 1/119 Т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус алба 2018 оны 2 дугаар улирлын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтын ажлыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтуудын ачааллаас шалтгаалан 2018 оны 10 дугаар сард хийж гүйцэтгээд үр дүнг Аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.

ДАРГА  Б.НАРМАНДАХ



Н.Монх-зурна
 Төрийн захирал


2518310

Саналд өгөх тайлбар:

Тайлангийн төсөлд тусгах санал байхгүй ба 2018 оны 2 дугаар улирлын байдлаар шилэн дансны үйл ажиллагаанд хийгдээгүй хяналт шалгалтыг 10 дугаар сард хийж, үр дүнг хэлэлцүүлэхээр байна гэсэн тайлбарыг ирүүлжээ.

[Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт]

ҮАГ-НАГ/2018/01-НА

ДҮГНЭЛТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар илэрсэн нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, мэдээллийг 87,8 хувьтай байршуулжээ.

2. Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансанд байршуулах мэдээллийг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна.

3. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд дараа жил нь үйл ажиллагаа явуулах эсэх нь тодорхойгүй байхад цахим хуудаст шинээр цэс нээж, мэдээлүүлэх нь хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй байна.

4. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дах хэсэгт заасан байгууллага, албан тушаалтнууд холбогдох хяналтыг тухай бүр хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчил дутагдал бүрэн арилахгүй, дахин давтагдан гарсаар байна.

5. Санхүүгийн хяналт аудитын алба нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 8.2³⁰-т заасны дагуу ТЕЗ-ийн 2018 оны 2 улирлын шилэн дансны тайланд хяналт шалгалт хийж холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



³⁰ "Дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ.."

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

НЭГ. АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА Ц.ОТГОНБАЯР ТАНАА

1. Бүх шатны ИТХ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, энэ талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг тооцож ажиллах.

ХОЁР. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛ ТАНАА

1. Төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагуудаар шилэн дансанд мэдээллийг нөхөн байршуулж, хэрэгжилтийг тооцож ирүүлэх.

2. Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны мэдээллийг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-3.1-т заасны дагуу тогтсон хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

3. Хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгжүүдийн шилэн дансанд байршуулах мэдээллийг аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд батлагдсан маягтаар улирал бүр нэгтгэж, бүрэн мэдээлж байх.

4. Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасан аж ахуйн нэгж, байгууллагуудад хуулийг хэрэгжүүлэх талаар сургалт явуулж, шилэн дансанд байршуулж буй мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллах.

5. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг мөрдүүлж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах.

ГУРАВ: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА

Б.НАРМАНДАХ ТАНАА

1. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1³⁰, 8.2³¹-т заасны дагуу дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллах.

³⁰ “ Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр ТЕЗ-ийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана..”


³¹ “Дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ..”

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэхгүй болсон татан буугдсан байгууллагуудыг Сангийн яаманд мэдэгдэж, шилэн дансны цэсийг цэгцлэх.

Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 37

Номгон

Г Аудитын тайланг баталгаажуулах тухай Г

Монгол Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/188 тоот тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан "Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх"-ийн 1.1, 2.4 дэх заалт, 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталж, албан шаардлагын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /Б.Должмаа/-д үүрэг болгосугай,

Гурав. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй

Дөрөв. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Б.Должмаа/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /Д.Цэцэгмаа/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Б. МӨНХБАТ

2518016